

## МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ

Д.ОЮУНЧИМЭГ  
МУИС. Улс төр судалын тэнхимийн ахлах багш

**Түлхүүр үг:** “Улс төрийн нам”, “намын имиж”, “сонгуулийн кампанит ажил”.

**Хураангуй:** Иргэд, сонгогчдын зүгээс улс төрийн намыг таньж мэдэх, сонгон элсэх, сонгуульд санал өгөх зэрэг бүхий л үйл явцад тухайн намын имиж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байдаг.

Улс төрийн намуудад үл итгэх хандлага нэмэгдэж, сонгогчдын үнэлэмж буурч байгаа хандлага өнөөгийн улс төрийн намуудын имижийн суурь болж байна. Улс төрийн намуудыг, “Улс төрийн намын тухай хууль”-ийг өөрчлөх цаг болсон. Намуудыг сайжруулахын тулд тэдний эрх мэдлийг нэмж болохгүй. Харин ч хязгаарлалтууд хийж, хариуцлагын тогтолцоог нь оновчтой болгох нь зүйтэй. Улс төрийн намд эерэг имиж бүрдүүлнэ гэдэг бол намын улс төрийн хариуцлагыг дээшлүүлнэ гэсэн үг. Бодит өөрчлөлт үгүй бол хоосон зүйлийг яж ч магтаад имижийг нь өөрчилж чадахгүй.

Улс төрийн намууд бүрэн утгаараа “бодлогын нам” болж чадах аваас намын боловсон хүчний бодлого, санхүүжилт, дотоод ардчилал, гишүүнчлэл, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт зөв гольдрол руугаа эргэх байзаа.

\* \* \*

Монголд улс төрийн нам 1921 онд үүссэнээс хойш түүхэн өөр өөр үеүдийг туулж, эдүгээ 100-аад жилийн нүүр үзэж, олон намын тогтолцоонд шилжээд байгаа хэдий боловч өнөөдөр ч цэгцрээгүй асуудлуудаар дүүрэн оршиж байна.

Монголын улс төрийн намууд өнөөдөр ямар имижтэй байна вэ? гэсэн асуултанд хариулахын тулд “нам” хэмээх ойлголтын имиж ямар байгааг авч үзэх шаардлагатай болно. Монголын сонгогчид “нам” хэмээх ойлголтонд юуг төсөөлж байна вэ? Өнгөрсөн 70 жилд улс төрийн намыг “нам бол манай үеийн оюун ухаан, нэр төр, нандин чанар” гэж ойлгож ирсэн ойлголтоос эхлээд, “нам бол улс төрийн систем доторхи өргөс юм” гэсэн ётг зүйрлэл хүртэл улс төрийн намыг “социологийн”, “зорилго-үйл ажиллагааны”, “гүн ухааны”, институциональ, системийн гэх зэрэг янз бүрийн хандлагуудаар тодорхойлсон олон тодорхойлолт буй ч өнөөгийн сонгогчдын дунд хамгийн нийтлэг, харьцангуй шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголт нь “Нам бол нийгмийн бүлгийн сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн тодорхой зорилгоор нэгдсэн иргэдийн сайн дурын байгууллага”, “Нам бол төлөөлөгчдөөрөө дамжуулан засгийн эрхийг барих буюу барилцахын төлөө тэмцэж байдаг хүмүүсийн бүлэг” гэсэн хандлага түлхүү байна.

Имиж улс төрийн лидерт хэрэгтэй байж, түүнийг амжилт хийгээд ялагдалд хүргэж байдаг зүйл төдийгүй төрийн эрх барихын төлөө өрсөлдөж буй улс төрийн намуудад түүнээс ч дутуугүй хэрэгцээтэй зүйл юм. Улс төрийн намын имиж гэж юу вэ? Энгийнээр тодорхойлбол, тухайн намын талаархи олон нийт, сонгогчдын сэтгэгдэл, дүр төсөөлөл, үнэлгээ юм.

Олон нийт, сонгогчдын талархал, дэмжлэг бол улс төрийн намын оршин тогтонох, амжилтанд хүрэх үндэс. Улс төрийн намын имижийг тодорхойлохын тулд тухайн намын үзэл баримтлал, үнэт зүйлс, мөрийн хөтөлбөр, дүрэм журам, олон нийттэй тогтоосон холбоо харилцаа, явуулж ирсэн хийгээд явуулж буй үйл ажиллагаа, түүний арга хэлбэр, дотоод ардчилал, санхүүжилт, лидерүүдийн нэр хүнд, боловсон хүчний бодлого зэрэг бүхий л хүчин зүйлсийг хөгжил хөдөлгөөн дунд нь авч үзэх шаардлага тулгарна. Эдгээр хүчин зүйлс бүхэн тухайн намын имижийг бүрдүүлэхэд өөр өөрийн нөлөөгөө ямагт үзүүлж байдаг.

Аливаа институтын оршин тогтонох, амжилт олох үндсэн, гол хүчин зүйлийн нэг нь түүний имиж. Улс төрийн намыг танин мэдэх, сонгон элсэх, сонгуульд санал өгөх зэрэг бүхий л үйл явцад тухайн намын имиж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байдаг.

Монголын улс төрийн намуудын өнөөгийн нэр хүнд, имиж ямар байна вэ? Үүнийг хэн нэгэн судлаач өөрийн таамаглалаар тодорхойлж болохгүй. Гагцхүү сонгогч иргэдийн үнэлэлт дүгнэлт, хандлагаар тодорхойлогдоно.

Улс төрийн намуудад үл итгэх хандлага нэмэгдэж, сонгогчдын үнэлэмж буурч байгаа явдал өнөөгийн улс

төрийн намуудын имижийн үндэс болж байна.

Монголд нам тус бүрийн имиж ямар байна вэ гэхээс өмнө “Нам”гэж юу вэ? Өнөөгийн нийгэмд **намын** гүйцэтгэж буй үүрэг роль, энэ талаархи олон нийтийн үнэлэлт дүгнэлтийг авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл “улс төрийн нам” гэсэн ерөнхий ойлголтын имиж чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Олон нийтийн дунд “улс төрийн нам бол авилгын загалмайлсан эцэг”, “улс төрийн нам бол албан тушаал хөөцөлдсөн хүмүүсийн бүлэг”, “улс төрийн нам бол хоосон амлагчид”, “улс төрийн нам бол нийгмийг хагалан бутаргагчид” гэх зэргээр сөрөг имиж оршин үйлчилж байвал аль ч улс төрийн намд сөргөөр нөлөөлнө.

Харин “улс төрийн нам бол нийгмийн идэвхитэй хэсгийн нэгдэл”, “улс төрийн нам бол оюуны “think-tank” (шинжээчдийн хэсэг, бодлого боловсруулах хэсэг) төв”, “улс төрийн намууд байж гэмээнэ нийгмийн улс төрийн тогтолцоо бүрэлдэнэ” зэргээр зэрэг имиж оршин үйлчилж байвал бүхий л улс төрийн намуудын үйл ажиллагаанд таатай суурийг тавьж өгнө.

Гэвч энэ суурин дээр ордон сүндэрлүүлэх, эсвэл муухан майхан барьж тэр нь нуран унах эсэх нь тухайн намаас бүрэн хамаарна.

Монголын улс төрийн намууд өөр өөрийн имижтэй оршиж, тэрхүү имиж нь тодорхой хугацаанд өөрчлөгдж байдаг.

Монгол улсад өнөөгийн байдлаар Дээд шүүхэд бүртгэлтэй нийт 24 улс төрийн нам байна. Үүнд:

№	Намуудын нэрс	Нэрийн товчлол	Байгуулагдсан он.сар	Гишүүдийн тоо	Тайлбар	Намын дарга
1	Монгол Ардын нам	МАН	1921.03.01	161,300	1924-2010 онд Монгол Ардын Хувьсгалт нам нэргээж байсан	М.Энхболд
2	Ардчилсан нам	АН	2000.02.06	150,000	МУАН, МСДН, МШАН, МоАН, МАСМН зэрэг намууд нэгдсэн	С. Эрдэнэ
3	Монголын Ногоон нам	МНН	1990.05.13	2,100	2012 онд ИЗНН-тай нэгдэхгүй гэсэн хэсэг нь намаа авч үлдсэн	О.Бум-Ялагч
4	Иргэний Зориг ногоон нам	ИЗНН	2000.03.23	35,000	2002 онд БНН - тай нэгдэж Иргэний зориг – Бүгд найрамдах нам болсон ч 2006 онд эргэн ИЗН болсон. 2012 онд МНН – ын хэсэгтэй нэгдэж ИЗНН болсон.	Ц.Ганхуяг
5	Монголын Уламжлалын Нэгдсэн нам	МУНН	1993.12.05	1,503	ММТНН, МХӨНН, МТТ зэрэг нам нэгдэж байгуулагдсан	Б.Батболд
6	Монголын Либерал Ардчилсан нам	МЛАН	1998.03.05	863		Т.Төмөрмөнх
7	Эх Орон нам	ЭОН	1998.12.16	160,000	Монголын Ардчилсан Шинэ Социалист нам нэргээж үүсч, 2000 онд Эх орон – МАШСН, 2005 онд одоогийн нэрээ авсан.	Б.Эрдэнэбат
8	Монголын Либерал нам	МЛН	1999.12.17	1,300	МИАШЛН нэргээж үүссэн	Б.Амгаланбаатар
9	Бүгд Найрамдах нам	БНН	1992.04.07	50,000	2002 онд ИЗНН – тай нэгдэж, 2004 онд тусгаарлаж, 2006 онд шинээр бүртгүүлсэн	Б.Жаргалсайхан
10	Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний нам	МЭҮН	2003.12.16	1,069		Г.Тунгалагтэрэл

11	Монголын социал демократ нам	МСДН	2004.12.19	3,000	1990 – 1999 онд МСДН байсан. 1999 онд бусад намуудтай нэгдэн АН-ын нэг хэсэг болсон. 2004 онд намаа сэргээн байгуулсан	А.Ганбаатар
12	Ард түмний нам	ATH	2005.12.11	11,859		Н.Наранцогт
13	Монгол үндэсний арчилсан нам	MYAH	2006.05.19	26,000	Үндэсний Шинэ нам нэрээр байгуулагдсан. 2011 онд нэрээ одоогийнхоор сольсон	М.Энхсайхан
14	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	ЭЧХН	2006.10.09	1600		Ш.Төмөрсүх
15	Иргэний хөдөлгөөний нам	ИХН	2007.08.17	815		Б.Батсайхан
16	Хөгжлийн Хөтөлбөр нам	ХХН	2007.10.28	933		О.Заяа
17	Монголын Арчилсан Хөдөлгөөний нам	МАХН	2008.02.01	850		Т.Оюунаа
18	Монгол Ардын Хувьсгалт нам	МАХН	2011.01.28	35,000	МАХН нэрээ МАН болгож солихыг эсэргүүцсэн хэсэг олонхоосоо салан байгуулсан нам	Н.Энхбаяр
19	Хамуг Монголын Хөдөлмөрийн нам	ХМХН	2011.09.23	2,000		Ц.Шинэбаяр
20	Хөдөлмөрийн Үндэсний нам	ХҮН	2011.12.05	1,024		С.Боргил
21	Эх Орончдын Нэгдсэн нам	ЭОНН	2012.03.12	2,150		Г.Ганбат
22	Монгол Консерватив нам	МКН	2012.06.20	959		Н.Дашдаваа
23	Тусгаар Тогтол, Эв нэгдлийн нам	ТТЭНН	2015.04.18	3,131		Г. Уянга
24	Ард Түмнээ Хайлдаж нам	АТХН	2015.04.20	1,388		Л.Гүндалай

№	Намуудын нэрс	Үзэл баримтлал
1	Монгол Ардын нам (МАН)	Нийгмийн арчилал (социал демократ), зүүн төвийн
2	Арчилсан нам (АН)	Либерал, баруун төвийн
3	Монголын Ногоон нам (МНН)	Социал демократ, ногоон, зүүн төвийн
4	Иргэний Зориг ногоон нам (ИЗНН)	Неолиберал, ногоон, баруун төвийн
5	Монголын Уламжлалын Нэгдсэн нам (МУНН)	Консерватив, зүүн төвийн
6	Монголын Либерал Арчилсан нам (МЛАН)	Либерал, баруун
7	Эх орон нам (ЭОН)	Арчилсан социалист, зүүн төвийн
8	Монголын либерал нам (МЛН)	Либерал, баруун
9	Бүгд найрамдах нам (БНН)	Консерватив, баруун төвийн
10	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нам	Консерватив, үндэсний арчилсан
11	Монголын социал демократ нам (МСДН)	Социал демократ, зүүн төвийн
12	Ард түмний нам (ATH)	Үзэл баримтлал тодорхойгүй, баруун төвийн
13	Монгол үндэсний арчилсан нам (MYAH)	Үндэсний арчилсан, баруун төвийн
14	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам (ЭЧХН)	Үзэл баримтлал тодорхойгүй, баруун төвийн
15	Иргэний хөдөлгөөний нам (ИХН)	Консерватив, зүүн төвийн
16	Хөгжлийн Хөтөлбөр нам (ХХН)	Үзэл баримтлал тодорхойгүй, баруун төвийн
17	Монголын Арчилсан Хөдөлгөөний нам	Либерал, баруун

18	Монгол Ардын Хувьсгалт нам (МАХН)	Социал демократ, зүүн төвийн
19	Хамуг Монгол Хөдөлмөрийн нам (ХМХН)	Социал демократ, зүүн төвийн
20	Хөдөлмөрийн Үндэсний нам (ХҮН)	Социал демократ, зүүн төвийн
21	Эх Орончдын Нэгдсэн нам (ЭОНН)	Үзэл баримтлал тодорхойгүй, зүүн төвийн
22	Монгол Консерватив нам (МКН)	Консерватив, баруун төвийн
23	Тусгаар Тогтолц, Эв нэгдлийн нам (ТТЭНН)	Үзэл баримтлал тодорхойгүй, зүүн төвийн
24	Ард Түмнээ Хайрлая нам (АТХН)	Үзэл баримтлал тодорхойгүй, баруун төвийн

**Монголын улс төрийн намуудын үзэл баримтлал:** Судлаачдын тодорхойлсноор (Я.Төмөрбаатар.2014) Монгол улсад 2014 онд “улс төрийн 21 нам байснаас: 6 нь зүүн төвийн болон зүүний, 7 нь барууны болон неолиберал баруун төвийн, 4 нь консерватив, 4 намын үзэл баримтлал нь тодорхойгүй, зорилтоос нь үзвэл зүүн, барууны намуудын зорилтуудаас аль аль нь орсон намууд” байсан бол, 2016 онд Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн нийт 24 нам байгаагаас ерөнхий чиг хандлагаар нь авч үзвэл: “баруун болон баруун төвийн нам 13, зүүн болон зүүн төвийн нам 11 гэж тоймлож болохоор бол харин улс төрийн үзэл баримтлалаар нь авч үзвэл: социал демократ үзэл баримтлалтай нам 7, либерал үзэл баримтлалтай нам 6, консерватив үзэл баримтлалтай нам 6, үзэл баримтлал нь тодорхой бус нам 5 байна.

Намууд үзэл баримтлалын хувьд давхцал ихтэй, ялгарал тод бус болох нь харагдаж байна. Түүнчлэн зарим намын баримт бичиг сонгогчид уншаад ялгаж танихааргүй эрээвэр хураавар байна. Жишээ нь “либерал” ба “неолиберал” үзэл баримтлалын ялгаажирийн иргэд сонгогчид олж харахааргүй бүдэгтусгагдсан байна. Энд зөв буруу, сайн муу үзэл баримтлал гэсэн ойлголт огт байхгүй. Гагцхүү имиж бүрдүүлэлтийн нэг гол хууль болох “ялгарах” үзэгдэл сүл байна. Тиймээс улс төрийн намуудыг иргэд сонгогчдын зарим хэсэг нь далбаа, бэлэгдэлээр нь, цөөн хэсэг нь “Эрэлийн Эрдэнэбатын нам”, “Буянгийн Жагаагийн нам” гэх зэргээр намын даргаар нь таниж ялгах гэж оролддог байна.

Тэгвэл ижил үзэл баримтлалтай намуудад ялгарал байх боломж бий юу? Боломжтой. Жишээ нь социал демократ үзэл баримтлалтай намууд Монголд төдийгүй дэлхийд олон байгаа. МАН, МАХН аль аль нь социал демократ үзэл баримтлалтай ч бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлэх арга замаараа ялгахаар бүрэн боломжтой.

Ямар ч структур өөрийн гэсэн үзэл суртал, онол, номлолыг бий болгох хэрэгтэй болдог. Эс тэгвэл тэдний “имиж” нийлж, холилдож эхэлдэг. Үзэл суртал, номлол нь улс орны төвшний, кафеын төвшний зэргээр төвшин нь эрс өөр боловч гүйцэтгэх үүрэг нь ижил.

Зарим нэг шинэ сонгогчид “Намын мөрийн хөтөлбөр”, “Сонгуулийн мөрийн хөтөлбөр” хоёрыг хольж хутгах явдал мэр сэргэжиглагддаг. Аливаа намын мөрийн хөтөлбөр харьцангуй тогтвортой байдаг бол тухайн намаас сонгуулийн үеэр дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь цаг үеийн шинжтэй асуудлуудыг тусгасан, тодорхой цаг хугацаанд хэрэгждэг зэргээрээ онцлогтой.

Аль нэг намын “Намын мөрийн хөтөлбөр”-ийг тухайн намын гишүүд, сонирхон судлаач нараас бусад иргэд сонгогчид төдийлөн унишж танилцдаггүй бол харин намуудаас сонгуулийн үеэр сонгогчдод тараадаг “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-тэй сонгогчдын тодорхой хэсэг ямар нэг хэмжээгээр танилцдаг. Гэвч намуудын үйл ажиллагааны удирдамж болсон эдгээр мөрийн хөтөлбөрүүд нь хүрч болох амжилтыг тоогоор илэрхийлэн бичсэн байдаг ч түүнийгээ хэрэгжүүлэх арга зам нь тодорхой бус, тунхагийн шинжтэй, мөрөөдлийн жагсаалт мэт ойлгогдог төдийгүй тэр нь сонгуулийн 4 жилд үл биелэх, алс ирээдүйн зөgnөл гэж индүүрэгдэхээр “Монгол хүн - 2020”, “Монгол Улс - 2030” гэх зэрэг нэр өгч хэн нь алсын хараатай болохоо харуулах гэж өрсөлддөг. Гэтэл сонгогчдын олонхид ирэх 4 жилд юу хийх, түүнийгээ яаж хийх, онөөдөр тулгамдаад буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга зам, авч явах бодлого чухал байдаг.

“Сонгогчид сонгуулийн мөрийн хөтөлбөрийг огт уншдаггүй. Тэд бэлэн амлалт харж саналаа өгдөг” хэмээсэн ямар нэг шинжлэх ухааны үндэстэй нотолгоо байхгүй ойлголтонд намууд тулгаарлаж ирсэний хор уршиг оршсоор байна. Нөгөө талаас “сонгогчид уншдаггүй” гэж үздэг хэдий ч улс төрийн намууд, нэр дэвшигчид “сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэвлэх, хувилах, тараах, сурталчлахад ихээхэн зардал гаргасаар байна. Гэтэл үүндээ зардал багатай, сонгогчдын эрэлт шаардлагад нийцсэн арга хэрэгслүүдийг сонгож ажиллаж чадахгүй байгаа нь эргээд “сонгогчид уншдаггүй” нөхцөл байдлыг нэмэгдүүлж байна. Иймээс улс төрийн намууд сонгогчдоо буруутгах бус, өөрсдийн арга барилдаа өөрчлөлт хийснээр намынхаа имижийг осгөж чадна.

Сонгуулийн кампанит ажил амжилттай явагдаж ялалтанд хүрэхэд сайн мөрийн хөтөлбөр, тойрогтоо өрсөлдөх чадвартай нэр дэвшигчээс гадна тухайн намын даргын имиж чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс ч бусад улс орнуудын нийтлэг туршлагаас харахад хамгийн нэр хүндтэй, имижээ зөв бүрдүүлсэн лидерээр

намаа толгойлуулж сонгуульд оролцдог. Эерэг имижтэй, имижээ зөв бүрдүүлсэн лидер өөрөө тойротоо яалт байгуулаад зогсохгүй бусад тойрот өөрийн намаас нэр дэвшигчидээ дэмжлэг үзүүлж чаддаг бол имижээ зөв бүрдүүлээгүй лидер бусад нэр дэвшигчийнхээ имижийг “унагахгүй” байлаа ч гэсэн “сарниахад” хүргэдэг талтай.

Улс төрийн намын зүгээс сонгуульд нэр дэвшигчдээ шалгаруулах явдал ихээхэн ач холбогдолтой төдийгүй түүний шалгуур нь анхаарал татдаг. Сонгуульд нэр дэвших нь ямар нэг шагнал урамшуулал бус үүрэг, хариуцлага, итгэл юм. Нэр дэвшигчийн хамгийн гол шалгуур юу вэ? “бүхнийг мэдэгч байх”, “мөнгөтэй байх”, намын партизан байх” зэрэг үзүүлэлтүүд оновчтой шалгуур мөн үү? Сонгуульд нэр дэвшүүлэхэд тухайн нэр дэвшигчийн имиж нэн чухал үүрэг рольтой.

Имиж хоосон орон зайд бүрэлдэхгүй. Хэл ам хэрэг төвөгт орооцолдоогүй, хэлсэндээ хүрсэн, хийж бүтээсэн юмтай хүнд л эерэг имиж бүрэлдэх бололцоо үүснэ. Харин энэхүү бололцоогоо бодит байдал болгож, зөв “хайрцаглаж”, коммуникацийн суваг, арга хэрэгслээ оновчтой сонгон ажиллаж чадах эсэхээс бүх зүйл шалтгаалдаг.

Сонгуульд нэр дэвшигч бүрт ямар имиж бүрдэх, тэрхүү имижийнх нь хэдэн хувь нь урсгалаараа бүрэлдсэн, хэдэн хувийг нь зохион байгуулалттайгаар бүрдүүлсэн бэ? гэдэг өөр өөр.

Нэр дэвшигчийн имижийг “хайрцаглах”-д “бусдын нэг адил байх”, “бусдаас өөр байх” гэсэнхоёр хандлагын аль нь зөв бэ? гэсэн асуултыг сонгуулийн менежерүүд нэг бус удаа асуудаг. Энэ хоёр хандлагын аль нэгийг сонгон хэрэглэх бус харин хоёуланг нь зэрэгцүүлэн зохистой (бүх нэр дэвшигчдэд тохирдог жор үгүй) хэрэглэж байж үр дүнд хүрнэ.

Ямар ч нэр дэвшигч нас, хүйс, үзэл баримтлал, нам, эвсэл зэрэг “корпоратив буюу бүлгийн имиж”-ээсээ ангид байх боломжгүй. Улс төрийн намын тань имиж таны амжилтын үндэс.

Намын дотоод ардчилал, хүний нөөц-боловсон хүчний бодлого, санхүүжилт ил тод эсэх зэрэг олон асуудлууд намын гишүүдийн дунд, улмаар нийт иргэд сонгогчдын дунд “намынимиж”-ийг бүрэлдүүлж байдаг. Тухайн нам сонгогчдод л “сайн”-аар харагдаж байвал дотоод асуудал гол бус гэж үзэх хандлага ч байдаг. Гэвч улс төрийн нам гишүүдийнхээ талархлыг хүлээж чадахгүй бол сонгогчдын талархлыг хүлээнэ гэдэг нэн хэцүү.

Цаашилбал намын үйл ажиллагаа ил тод, гишүүд, анхан шатны байгууллагуудаа сонсож чаддаг эсэх чухал нөлөөтэй. Орон нутагт намын нэр нүүр, имижийг авч явагчид нь намын жирийн гишүүд, намаас орон нутагтаа сонгогдож, томилогдон ажиллаж буй иргэдийн хурлын төлөөлөгчид, төрийн алба хашигчид байдаг. Ийнхүү улс төрийн намууд өөрийн имижээ олон талт имижийн хэв маягийн дагуу авч үзсэний үндсэн дээр задлан шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, “засварлаж”, “хайрцаглаж” хэлбэржүүлж байдаг. Үүнд: “олон нийтийн төсөөлөл дэх тоймчилсон утгатай имиж”, “үйл ажиллагааны имиж”, “намын гишүүдийн имиж”, “үзэл баримтлалын имиж”, “намын хөтөлбөр, дүрмийн имиж”, “УИХ дахь гишүүдийн болон намын бүлгийн имиж”, “намын даргын имиж”, “сонгуулийн мөрийн хөтөлбөрийн имиж”, “сонгуулийн кампанит ажлын имиж” гэх зэрэгээр задлан шинжилгээ хийж, улмаар нэгтгэн дүгнэсний үндсэн дээр ажиллана.

Намын дотоод ардчилал, боловсон хүчний бодлого, “бодлогын нам” байх гээд зангилаа асуудлуудын цаад талд “чөдөр, тушаа” болж байгаа асуудлын нэг бол “намын санхүүжилт”. Улс төрийн намын санхүүжилтыг тухайн намын дотоод асуудал гэж үзвэл эндүүрэл болно. “Монголын ардчилал “чанаргүй” байхад нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг нь улс төрийн намууд юм” (Улс төрийн нам: Асуудал, Эрэл, Шийдэл” Э.Ш-ний бага хурлын эмхтгэл, УБ., 2014. 22-р тал) Улс төрийн намуудыг “муухай” болгож харагдуулж байгаа нэг хүчин зүйл нь “түүний санхүүжилт” гэж болно.

**Нам байхын утга учир юу вэ? Нам яагаад засгийн эрх авах эрмэлзлэлтэй байдаг вэ?**

Энгийнээр хэлбэл төрийн бус байгууллага олон түмний сонирхлыг бүлэглэж илэрхийлдэг бол улс төрийн нам олон түмний сонирхлыг бодлого болгон дэвшүүлдэг бөгөөд дэвшүүлсэн бодлогоо хэрэгжүүлэхийн тулд засгийн эрх авах эрмэлзлэлтэй байдаг.

Намын гишүүн байхын утга учир юу вэ? Намын гишүүд бол нийгмийн идэвхитэй хэсэг. Намын гишүүн хүн нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг олж харж гарц эрэлхийлдэг, улс төрийн сонирхлоо мэдэrsэн байх ёстой. Иргэд улс төрийн намд элсэхдээ улс төрийн сонирхлоороо нэгддэг. Иймээс улс төрийн бодлого, шийдвэрт ямагт оролцож нөлөөлөх эрмэлзлэлтэй байдаг.

**Нам бодлого, хөтөлбөрөө хэрхэн боловсруулан гаргасан, гишүүд хэрхэн оролцсон?**

Нам гишүүдийнхээ төдийгүй сонгогчдын хүсэн хүлээсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж чадсан уу?

Бусад намуудаас ямар ялгаатай? юу нь давуу вэ? Намаас сонгуульд хэнийг нэр дэвшүүлж байна вэ? Эдгээр асуултын хариулт тухайн намын талаархи үндсэн дүр төрхийг илтгэдэг.

Сонгуульд хангалттай санал авч засгийн эрхийг авч чадаагүй ч гэсэн парламентад суудал авч шийдвэр гаргахад оролцох эрхтэй болж чадах эсэх нь улс төрийн намын томоохон шалгуур.

Сонгууль бол сонголт хийх үйл ажиллагаа. Сонгогчид юу сонгодог вэ? Сонгуульд оролцсоноор: бодлогын сонголт, хөтөлбөрийн сонголт, арга замын сонголт, нэр дэвшигчийн сонголт, шударга ёсны сонголт, сайн, сайхан амьдралын сонголт хийдэг.

“Ардчиллын хамгийн минимум шалгуур болсон чөлөөт, шударга сонгуулийгзохион байгуулах нь ардчилтыг тогтоон барих энгийн арга хэрэгсэл мөн. Бид сонгуулийг жинхэнэ утгаар нь явуулж эс чадваас сонгуулиар халхавчилсан квази-ардчилал тогтох, ард түмэн улс төрийн талбар дахь хэдхэн тооны олигархийн тогтолтыг харж суудаг үзэгчид төдий болох аюултай. Ардчилал, сонгууль хоёр нэг зоосны хоёр тал юм.” (Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль” Э.Ш-ний бага хурлын эмхтгэл, УБ., 2009.11-р тал)

Сонгуулийн кампанит ажил 18 хоног болсон нь нэг талаасаа хөрөнгө, хүн хүч хэмнэсэн сайн талтай ч нөгөө талаасаа сонгогчдын мэдээлэл авах эрх болон нэр дэвшигчид, улс төрийн намууд, бие даан нэр дэвшигчдэд сурталчилгаагаа явуулах боломжийг нь хязгаарласан. Хэдий тийм боловч, нэгэнт бүрдсэн имижийг “хайрцаглахад” хүрэлцэх хугацаа юм.

Сонгуулийн кампанит ажлуудын туршлагаас харахад улс төрийн намууд, нэр дэвшигчид “улс төрийн PR-ийг ихэд сонирхож, энэ чиглэлийн мэргэжилтнүүдэд ихээхэн ач холбогдол өгдөг. Үнэн чанартаа PR-ийн мэргэжилтний хэрэгцээ сонгуулийн кампанит ажлын хэдхэн хоногоос илүүтэйгээр урт хугацаанд илүү хэрэгтэй байдаг. Харин сонгуулийн кампанит ажлын цөөн хоногт “имижмейкер”-ын хяналт, үүрэг роль илүү чухал байж нэгэнт бүрдсэн имижийг “хайрцаглахад”, түүнийгээ сонгогчдод хэрхэн хүргэхэд голлон анхаарах ёстой. Мэдээж “хар PR”-нь цаг хугацаа шаардаад байдагтүй, өрсөлдөгчдөөс хэзээ ч ирэх боломжтой учир түүний эсрэг ажиллах PR-ийн мэргэжилтнүүд сонгуулийн кампанит ажлын хугацаанд хэрэг болно.

Ийнхүү имижмейкерийн үүрэг ролийг дутуу ойлгодог шиг “имижийн хууль”-ийг буруугаар ойлгох явдал ч ажиглагддаг. Имижийн хуулийг нэмэх, хасах, үржих, хуваах хэмээн математикийн дөрвөн үндсэн ухагдахуунаар нэрлэдэг ч түүнийг шууд утгаар нь ойлгож болохгүй. Энд ямар ч нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдлийн тухай яригдахгүй гагцхүү “зохицол” (гармония)-ын тухай яригдана.

Улс төрийн намын имиж бүрдүүлэхэд: 1-рт “чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн” буюу нийгмийн үнэт зүйлс, эрэлт шаардлагад нийцсэн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, нэр дэвшигч байх, 2-рт бусад улс төрийн намуудаас ялгаатай байх, ялгарч гарах, 3-рт хэнд, юуг, ямраар, хэзээ, хэрхэн хүргэх суваг, арга, хэлбэрийг зөв сонгох явдал нэн чухал. Улс төрийн намын имижийг бүрдүүлэх нь цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардсан хүнд ажил байдаг бол харин өчүүхэн алдаанаас болж тэрхүү бүрэлдсэн имиж унах, сарнихад хүрдэг.

Улс төрийн намын үндсэн шалгуурын нэг бол сонгууль. Иймээс улс төрийн намуудыг аль нэг шатны сонгуульд бүртгүүлж өрсөлдөхгүй бол бүртгэлээс хасах, үйл ажиллагааны идэвхи, бодлого чиглэл зэргийг харгалzan бүртгэх, өөрөөр хэлбэл бодит чадамж, хүсэлгүй бол бүртгэхгүй байх, намын дүрмийн заалтуудад хуультай зөрчилдсөн, хууль дээгүүр алхсан зүйл заалт байх аваас бүртгэхгүй байх зэргээр нам үүсгэн байгуулах хийгээд үйл ажиллагаа явуулах эрхээ хадгалж байх тодорхой шалгуурууд тавьж болох юм.

Өнөөдөр Монгол улс Үндсэн хуулиндаа гар хүрэх эсэх талаар ихээхэн яриа өрнөж байна. Үүнээс илүү өөрчлөн шинэчлэх шаардлагатай хууль бол “Улс төрийн намын тухай хууль” юм. Улс төрийн намын талаархи хуулийн ач холбогдлын талаар Монголын болон гадны судлаачид олонтоо тэмдэглэсэн байдаг. Тухайлбал судлаач Д.Болд-Эрдэнэ “Намын тухай хууль бол нам, намын системтэй холбогдон гарсан харилцааг шууд төвлөрүүлэн зохицуулж байдаг эрх зүйн гол баримт бичиг” болохыг тэмдэглэсэн бол (Д.Болд-Эрдэнэ. “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил” УБ., 2008, 32-р тал) Оросын судлаач И.П.Ильинский “Намын тухай хууль бол улс төрийн намын эрх зүйн чухал уг сурвалж, иж бүрэн цогц хууль тогтоомжийн акт юм” (И.П.Ильинский “Политическая система современного капитализма” М., 1983, с-23) хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Улс төрийн намын тухай хуулийг 1990 онд баталснаас хойш 2005 онд шинэчлэн баталсан. Үүнээс хойш зарим нэг нэмэлт өөрчлөлтүүд орсоныг эс тооцвол уг хууль өнөөдрийг хүртэл үйлчилсээр байна. Өнөөдөр үйлчилж байгаа “Улс төрийн намын тухай хууль”-нд нухацтай хандаж, өөрчилж шинэчлэх шаардлагатай. Учир нь энэхүү хууль нийгмийн шаардлагыг хангаж, намуудын өсөлт хөгжил, төлөвшилтөнд зерэгээр нөлөөлж чадахгүй байна.

Зарим улс төрийн намуудын “дүрэм”-д МУ-ын хууль, парламентын гишүүний бүрэн эрхийг зөрчсөн зүйл

заалт үйлчилж байгаа нь эрх ашгийн дэс дараалал алдагдах, УИХ-ын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зөрчил үүсгэдэг байна. Жишээ нь “...өөрийн нам дангаар болон хамтарч байгуулсан Засгийн Газар, сонгогдсон Засаг даргыг намын шийдвэрийг зөрчин огцруулсан нь тогтоогдвол намаас хасах” (АН-ын дүрэм) гэсэн дүрмийн заалт намаас УИХ-д сонгогдон ажиллаж буй гишүүдийн бүрэн эрхтэй зөрчилдэг зэрэг олон жишээг дурьдаж болно. Нөгөө талаас “Улс төрийн намын тухай хууль”-нд сонгуулиар дамжуулж маш их эрх эдэлдэг улс төрийн намыг задгай орхисон нь нам, бүлгийн эрх ашиг, улс орны эрх ашгийн эрэмбэ алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Улс төрийн намын тухай хууль”-ийг шинэчлэн сайжруулах, намд тавигдах шалгуур, санхүүжилт, гишүүнчлэлийн талаар шинэчлэлт хийх хэрэгцээ шаардлага байгааг судлаачид тэмдэглэсээр ирсэн.

“Улс төрийн намын тухай хууль” зөвхөн улс төрийн намуудын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд төрийн тогтолцоо, эрх мэдлийн хуваарилалт, төрийн албаны чанар, намуудын дотоод ардчилал, авилгын асуудал, ардчиллын төлөвшил гээд улс төрийн амин чухал асуудлуутай холбогддог нь уг хуулийн онцлог, ач холбогдлыг илтгэж байна.

“Төр муу ажиллаж байна”, “Засгийн газар муу ажиллаж байна”, “Төр хүчгүй байна”, “УИХ данхайж бүх асуудлыг шийддэг болоод байна”, “Төрийн эрх мэдэл хуваарилалт алдагдаж байна”, “Засгийн газар, Парламент, “Шүүх”-д ч нам нөлөөлж байна”, зэрэг шүүмжлэлүүдийг хэлэх амархан. Харин энэ бүхний цаана яагаад ийм байдалд орж байна гэдгийг олон талаас нь нарийвчлан судлах шаардлагатай. “Засгийн газрын эрх мэдлийг нэмэх”-ээр бүх асуудал шийдэгдэнэ гэж харвал том алдаа болно. Ерөнхий сайдыг хүчирхэг болгож болохгүй. Харин байх ёстой эрхийг нь (“Засгийн газраа бүрдүүлэх эрх”, “Төсөвөө захиран зарцуулах эрх”-ийг нь) өгөх шаардлагатай. Намаас нэр дэвшээд, намаасаа татгалздаг улс төрийн хамгийн өндөр албан тушаал болох “Ерөнхийлөгч”-ийн эрх үүргийн хуваарилалтыг ч эргэж харах хэрэггарна. Хуулинд “хориг” тавих эрх байсаар атал “санаачлах” эрхийг давхцуулах хэрэгтэй юу? Шүүх засаглал заавал холбогдож байх ёстой юу? гэх зэрэг олон асуудлуудыг судлаачид төдийгүй улс төрийн намууд сонирхон судалж байна.

“Төрийн эрх мэдэл хуваарилалт”-ыг “хууль тогтоох”, “гүйцэтгэх”, “шүүх” гэсэн гурван хэсэгт яригддаг. Орчин үед ардчиллыг бүрэн утгаар нь хэрэгжүүлье “Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогшлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэвэл (Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.) “дөрөв дэх засаглал” болсон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтын үүрэг роль, хараат бус байдлыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх, “тав дахь засаглал” болсон иргэний нийгмийн оролцоог хангах явдал яригдана. Ингэснээр төрийн эрх мэдлийн таван салаа мөчир яригдаж болох юм.

Улс төрд өнөөдөр хамгийн их дутагдаж буй зүйл бол “хариуцлага”. Төрийн тэргүүн, Засгийн газар, УИХ, Шүүх –Хэн нь хариуцлага хүлээдэг вэ? Гэтэл энэ бүхний цаана “улс төрийн намууд хариуцлагагүй” байна гэсэн дүгнэлт гарч ирдэг. Улс төрийн хариуцлагыг эрх зүйн хэм хэмжээгээр үнэлэх, зохицуулах гэж оролддог нь үндсээрээ буруу бөгөөд гагцхүү ёс зүйн хэм хэмжээгээр үнэлж, дүгнэж, хариуцлага хүлээж сурсан нөхцөлд улс төр цэвэр ариун, хариуцлагатай байна. Практик дээрээс харахад албан тушаалтнууд “Би улс төрийн хариуцлага хүлээх ёсгүй. Учир нь “би хууль зөрчөөгүй” гэсэн хандлага үйлчилсээр байна. “Иргэн хүн хуулиар хориглоогүй бүхнийг хийх эрхтэй байдаг бол албан тушаалтан хуулиар олгогдсон эрх, үүргээ л хэрэгжүүлэх эрхтэй байдаг” гэсэн энгийн нэгэн дүрмийг хэрэгжүүлэхгүй байна. Буруу юм хийсний төлөө бус, зөв юм хийж чадаагүйн төлөө хариуцлага хүлээж суралыг нь эрх зүйн бус, ёс зүйн хэм хэмжээ юм.

Нөгөө талаас ёс зүйн хариуцлагаа өөрөө хүлээж байгаа албан тушаалтнуудыг иргэд үнэлж хүндэлж сураагүй байна. Тиймээс албан тушаалтнууд шүүхээр нотлогдсон гэмт хэрэг л биш бол ямар ч буруугүй гэж “гүрийдэг”, гүрийсэн нь ч зөв болдог. Учир нь алдаагаа зөвшөөрсөн албан тушаалтант манай иргэд сонгогчид улс төрийн тавцанаас бүрмөсөн зайлцуулдаг. Харин ихэнхи улс оронд бол эсрэгээрээ байж, тухайн хүнийг “ухамсартай, мэдрэмжтэй, хүнлэг” гэж үзэж эргэн ирэх үед эрэгээр хүлээн авдаг байна. Энэ бол өнөөгийн бидний олонхийн сэтгэл зүй дэх ялгаа юм.

Аль ч улс төрийн намд фракц байхыг үгүйсгэж болохгүй. Харин бүлэглэл байх нь хор уршигтай.

Үзэл онол, үнэт зүйлс, үзэл баримтлалын хувьд улс төрийн нам нэг, нэгдмэл байх хэдий ч асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэгт бүтээлч сэтгэлгээ, олон ургальч үзлийг дэмжсэн фракцууд үүсэж байх нь зүйн хэрэг. Фракцын гол онцлог бол тогтмол гишүүнгүй, асуудлын шийдлийн хувилбараар үүсч, нэгдэж, тарж байдаг, тогтмол бус үзэгдэл, үйл явц.

Харин бүлэглэл бол харьцангуй тогтвортой, тодорхой гишүүдтэй, бүхий л асуудлаар нэгдмэл байр суурьтай байж, бүлгийн эрх ашигтаа захирагдаж, бүлэгтээ түшиглэж байдаг. “АН-ын фракцууд” гэж ярьдаг ч тэр бол фракц бус “бүлэглэл” юм. Нам дотор бүлэглэл байх нь хор уршигтай.

Намын төлөвшил гэдэгт юуг ойлгох вэ? Монголд төлөвшсөн намууд байна уу? Улс төрийн намуудын төлөвшилт гэдэгт намуудын үнэт зүйлс, үзэл баримтлалын төлөвшил, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт,

дотоод арчилал, боловсон хүчний төлөвшил, бодлого боловсруулах арга механизм зэргийг авч үзнэ. Намын төлөвшилт бол харьцангуй ойлголт бөгөөд тасралтгүй явагдаж байдаг үйл явц юм.

Өнөөдөр нийгмийн зүгээс улс төрийн намуудаас юуг хүсэн хүлээдэг вэ? Монголын улс төрд учирч буй саад бэрхшээлийн цаана улс төрийн нам ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?

Бидний нэрлэдгээр иргэн Ламжав гуай нэгэнтээ “Монголд хамгийн сахилгагүй этгээд хэн бэ?—Нам. Боловсон хүчний бодлогыг хэн алдагдуулж байна? - Нам” хэмээсэн байдаг. Ажилд орж байгаа хүнд мэргэжлийн ур чадвар, чин сэтгэл хэрэгтэй. Гэтэл өнөөдөр ажилд орох, албан тушаал хашихад: намын харьяалал, өөртөө (намдаа, даргадаа) үнэнч гэсэн үзүүлэлтээр шалгуур хийж байна. Намуудыг сайжруулж, сахилгатай болгох уу?

Намуудыг сайжруулахын тулд тэдний эрх мэдлийг нэмж болохгүй. Харин ч хязгаарлалтууд хийж, хариуцлагын тогтолцоог нь оновчтой болгох нь зүйтэй.

Улс төрийн намд эерэг имиж бүрдүүлнэ гэдэг бол намын улс төрийн хариуцлагыг дээшлүүлнэ гэсэн үг, нийгэмд ойлгогдож буй сөрөг ойлголтуудыг үүсгэж байгаа дутагдлуудаасаа сална гэсэн үг.

Бодит өөрчлөлт үгүй бол хоосон зүйлийг яаж ч магтаад имижийг нь өөрчилж чадахгүй.

Намуудыг, намын тухай хуулийг өөрчлөх цаг болсон. Улс төрийн намууд “Бодлогын нам” болох аваас намын боловсон хүчний бодлого ч, санхүүжилт ч, дотоод арчилал ч зөв гольдрол руугаа эргэх болно.

**Abstract:** Political party image is crucially important for electorates making choice on political affiliation, voting process and policy support. Current tendency of electoral absenteeism and mistrust is current Mongolian political parties' widespread common image.

Building positive image of political party is tightly connected with the idea of increasing political responsibility of parties. Instead of making actual changes, current negative image of political parties will not go farther with useless flummery.

## НОМ ЗҮЙ:

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.
2. Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль. Төрийн мэдээлэл, №5, УБ., 2005
3. Монгол Ардын намын үндсэн дүрэм, хичээн эрмэлзэх зүйл, сонгуулийн мөрийн хөтөлбөр. 2016.
4. Ардчилсан намын дүрэм, мөрийн хотолбор, сонгуулийн мөрийн хотолбор, 2016.
5. Ардчилал ба улс төрийн нам, Онол-практикийн бага хурлын эмхтгэл, УБ., 2009.
6. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи: асуудал, аргачлал, ашиг тус. УБ.. 2013.
7. Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. УБ., 2008.
8. Острогорский М.Я. Демократия и политические партии. М., 1997.
9. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Э.Ш-ний бага хурлын эмхтгэл, УБ., 2009.
10. Почепцов. Г.Г. Паблик рилейшиз для профессионалов, “Ваклер” 2000.
11. Улс төрийн нам: Асуудал, Эрэл, Шийдэл” Э.Ш-ний бага хурлын эмхтгэл, УБ., 2014.
12. Шепель В.М. Имиджология. Секреты личного обаяния, М., 1994.